

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 10 2022 оны 8-р сар

■ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8-р сард уурхайн хаалтын төлөвлөлтийн мэргэжлийн баг Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний ерөнхий танилцуулга бүлгүүдийг боловсруулав. Үүнд: хууль эрх зүйн зохицуулалт, тавигдах шаардлага, төслийн эхний шатанд тодорхойлсон хаалтын төлөвлөлтийн зорилго, зорилтууд, Салхитын уурхайн ба үйл ажиллагааны танилцуулга, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын талаарх ерөнхий мэдээлэл гэх мэт бүлгүүд багтсан болно. Салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн уурхайн хаалтын төлөвлөлтийн мэргэжлийн багийг ажиллуулснаар олон салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг туршлага, ур чадвар, байр суурийг хаалтын менежментийн төлөвлөлтөд тусгаж улмаар шинжлэх ухааны үндэслэлтэй, практикт хэрэгжихүйц хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулахад чухал нөлөөтэй юм.

Мөн энэ сард MERIT төслийн баг төслийн II үе шатанд баримтлах оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны стратегийг тодорхойлоход анхаарч ажиллалаа. Энэ нь төсөл хэрэгжих хугацаанд талуудын оролцоог хангахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг чиглүүлэх төслийн чухал баримт бичиг юм. Түүнчлэн, төслийн гол оролцогч талуудыг төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр хангах зорилготой уулзалтыг Улаанбаатар хотод энэ сарын 26-нд зохион байгууллаа. Уулзалтын үеэр MERIT төслийн техникийн зөвлөх Р. Эрдэнэчимэг төслийн II үе шатанд хэрэгжүүлэх оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны стратегийг танилцуулсан бол “Эм И Си Эс Зэт Би” байгаль орчны зөвлөх компани 6-р сарын сүүлээр Салхитын уурхайн талбайд хийсэн хээрийн судалгааны ажил, гарсан үр дүнг танилцуулав.



Зураг 1. Төслийн оролцогч талуудын уулзалт

■ УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА


Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах төслийн 1-р шатанд MERIT төсөл нь уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтийн үндэсний чадавхыг бэхжүүлэх зорилгоор Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажилд монгол зөвлөхүүдийг оролцуулах санаачилгыг гаргасан билээ.

Төслийн 2-р шат эхлэхийн өмнө MERIT төслөөс үндэсний мэргэшсэн зөвлөхүүдийн нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Мэргэжлийн багт ажиллах хувь хүн болон мэргэжлийн компаниас бүрдсэн нийт 6 үндэсний зөвлөхийг сонгон шалгаруулсан. Үндэсний зөвлөх тус бүр өөрсдийн онцлог, үнэ цэнтэй мэдлэг, ур чадвар, туршлагад үндэслэн хаалтын менежментийн төлөвлөлтийн үйл явцад өөрийн хувь нэмрийг оруулан ажиллаж байна. Үндэсний болон олон улсын зөвлөхүүд, MERIT төсөл, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК нэг баг болж Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг хамтран боловсруулж байна.

Уурхайн хаалтын төлөвлөлтийн мэргэжлийн багийн гишүүд, тэдгээрийн төсөлд гүйцэтгэж буй үүргийг дор товч танилцуулав.

- Доктор Ш.Анармаа, уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтэн, “Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил судалгаа хөгжлийн төв” ТББ
- М.Даваасүрэн, редактор (MA & MLIS)
- “БАТ Юү Жи майнинг” ХХК-ийн хоёр гишүүнтэй баг, газар хэлбэршүүлэлт, дизайн
- “Макензи энд Партнерс” ХХК-ийн гурван гишүүнтэй баг, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн зардлын тооцоолол гаргах
- “Эм И Си Эс Зэт Би” ХХК-ийн 13 гишүүнтэй байгаль орчны мэргэжилтнүүдийн баг (агаарын чанарын шинжээч, хөрс судлаач, амьтан, ургамал судлаач, байгаль орчин, газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн)
- “Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан” (LEOS) ТББ-ын гурван гишүүнтэй баг (нийгэм-эдийн засаг, жендэрийн тэгш байдлын мэргэжилтнүүд)
- MERIT төслийн баг нь дөрвөн гишүүнтэй, төслийн ерөнхий удирдлага, оролцогч талуудын хамтын ажиллагаа
- Майк Посентэ, олон улсын зөвлөх, Канад улсын “Си Пи Пи Энвайронментал” корпораци
- Рачел Нобле-Паттинсон, байгаль орчны олон улсын зөвлөх, Канад улсын “Си Пи Пи Энвайронментал” корпораци
- “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг хүлээн авч хянах, төлөвлөгөөг шинэчлэх, хэрэгжилтийг хариуцах

Зураг 2. Уурхайн хаалтын төлөвлөлтийн мэргэжлийн баг



Үндэсний зөвлөхүүд, MERIT төслийн баг, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн мэргэжилтнүүд ирэх дөрвөн сарын турш уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдана. Уг сургалтаар багийн гишүүд уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтийн олон улсын тэргүүн туршлага, технологи, арга аргачлалтай танилцах юм.

■ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

MERIT төсөл Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн 2-р шатанд холбогдох талууд, нутгийн иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг хангахтай холбоотой үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөн, зохион байгуулах зорилгоор оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.

Төлөвлөгөөний зорилт:


- Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, мэдээлэл харилцааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх
- Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц боломжийг тооцоолж, оновчтой хуваарилах
- Нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхлыг баримтжуулан техникийн багт танилцуулж, хаалтын төлөвлөлтөд тусгах

Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө нь үндэсний зөвлөхүүд боловсруулж буй, Монгол улсын “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын шаардлагыг хангасан анхны жишиг баримт бичиг гэдэг утгаараа төрийн захиргааны байгууллага, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн удирдлагууд өндөр хүлээлттэй байгаа. Тиймээс, MERIT төсөл оролцогч талуудыг тогтмол мэдээллээр ханган, санал хүсэлтийг авч, дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэхэд өндөр ач холбогдол өгч, дээрх хүлээлтийг хангахыг зорьж байна.

Олборлох салбарт хэрэгжиж буй төслийн гол үе шатуудад нутгийн иргэдийг оролцуулах нь олон улсын шилдэг туршлага төдийгүй компаниуд нөлөөлөлд өртсөн иргэд, сонирхлын бүлгүүдийг тогтмол мэдээллээр хангадаг. Төслийн 2-р үе шатанд иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг чухалчлан авч үзэж байна. Уурхайн хаалтын төлөвлөлтийн мэргэжлийн баг Салхитын уурхай орчмын нутаг дэвсгэрт биечлэн ажиллаж, уурхайн хаалтын төлөвлөлтийн үйл явцыг тайлбарлан таниулж, нутгийн ард иргэд, малчдын санал хүсэлтийг авч төлөвлөгөөнд тусгана.

Цаашид MERIT төсөл нь төлөвлөлтийн багтай хамтран уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний гол бүлгүүдийг боловсруулах ажилтай (Зураг 3-т харуулсан хуваарийн дагуу) уялдуулан орон нутгийн иргэдэд мэдлэг мэдээлэл олгох, тэдний оролцоог нэмэгдүүлэх сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

Зураг 3. Төслийн 2-р үе шатанд хэрэгжүүлэх оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, хуваарь



ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
Төслийн захирал **Р.Алтангэрэл**тэй имэйл хаягаар холбогдоно уу.

✉ r.altangerel@merit.mn